

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АСУУДЛААРХ
МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ
(мэдээллийн сайтуудын жишээн дээр)

*Л.Ариун

*Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн Сэтгүүл зүй, медиатехнологийн
тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)

Түлхүүр үгс: Хөгжлийн бэрхшээл, мэдээллийн сайтууд, сэдэв, хөгжлийн бэрхшээлийг ойлгох нь

Хэвлэл мэдээлэл нь нийгмийн олон талт харилцааг зөв тайлбарлаж хэн нэгний санаатай, санамсаргүй хийсэн үг, үйлдлээс болж зовлон шаналалд автах хүний эрх ашгийг хамгаалж, эрх тэгш, шударга байдлыг сурталчилж ялгаварлан гадуурхалт, үзэн ядалт, гүтгэлэг доромжлолыг дэвэргэхээс сэргийлэн өрөөсгөл хандлагыг бууруулахад хамгийн их хүч нөлөөтэй нийгмийн институт билээ. Энэ үүднээс авч үзвэл мэдээлэл түгээж байгаа үйл ажиллагаандаа тогтмол анализ хийж юуг анхаарах, юунд алдаж байгаагаа эргэн харж нийгэм олон нийтээ тогтмол зөв сайханд уриалж, эерэг хандлага, хүлээн зөвшөөрөл, хүлцэл тэвчил, ойлголцолд дадуулж байх хэрэгтэй юм. Нийгэмд буруу тогтсон хэвшмэл ойлголт маш түгээмэл бий. Тодруулбал жендэр, нийгмийн цөөнх, гэмт хэргийг хохирогч, хөгжлийн бэрхшээлийн тухай хэвшмэлжин тогтсон

буруу ойлголтын талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл залруулж зөв ойлголт өнцгөөр мэдээлэх нь нийгэмд тэгш байдал, шударга ёсыг тогтооход хувь нэмрээ оруулж хохирсон, ялгаварлагдсан, гадуурхагдсан талыг бусдад ойлгогдох, хүлээн зөвшөөрөгдөх, эрхээ эдлэх боломжийг хангаж өгдөг ач холбогдолтой. Хамгийн гол нь мэдээллийн хэрэгсэл олон нийтийн итгэлийг олж, тэдний үгийг хүргэх, эрхийн хамгаалах, зөв жишиг тогтоох хүчтэй хэрэгсэл болж төлөвшин тогтох билээ.

Өдгөө дэлхийд гарч буй шинэ хандлага бол хэвлэл мэдээллийн байгууллагуудаас үйл ажиллагаагаа дахин төлөвлөх, нийгэм дэх үүрэг, чиг үүргээ сэргээх, мөн хэрэглэгчидтэйгээ илүү ойртож, тэдний итгэл үнэмшлийг эргүүлэн олж авахыг шаардаж байна. Хүн ам зүй, нийгэм, улс төрийн орчин дахь эрс өөрчлөлт, үзэгчдийн үзэл бодол, дадал зуршил, хүлээлтийн туйлшрал нэмэгдэж байгаа нь менежментийн шинэ туршлагыг нэвтрүүлэх, хэвлэл мэдээллийн салбарын үйл ажиллагааг шинэчлэх зайлшгүй хэрэгтэйг сануулсаар (НҮБ-

ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага, 2024) байгаа аж. Энэ үүднээс редакцууд болон хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлагын бүтцэд өөрчлөлт өрнөж буй хэдий ч олон талт байдлыг хангах асуудал одоо хүртэл сорилт хэвээр байгааг шинэ тутам нэмэгдэж буй академик нотолгоо, бизнесийн стратеги, үйл ажиллагааны тайлан, нийтийн хэлэлцүүлэг зэргээр баталсаар байна. Тодорхой бүлгийг, тэр тусмаа хөгжлийн бэрхшээлтэй үзэгчдийг үл ойшоох нь шинэ өнцөг, өгүүлэмжийг ашиглаж чадахгүй үлдээх, бүтээлч байдлаа бүрэн нээхгүй байх, тоогоор илэрхийлшгүй боломжит үр өгөөжийг үгүй хийх, зорилтот бүлгийн өмнө биелэгдээгүй амлалт үлдээх зэрэг олон сөрөг үр дагавартай. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон янзын үзэгчдэд хүрч чадахгүй байх нь нийгэм дэх иргэдийн санал бодол, үзэл бодолд ч нөлөөтэй гэдэг нь мадаггүй. (Janice Gassam Asare, "Recent Figures Show that Media Is Still Overwhelming White," Forbes,, 23 April 2023.)

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон талт байдлыг эрхэмлэх нь өргөн хүрээг хамарч, өсөн нэмэгдсээр буй хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгчдийнхээ чадамжийг нэмнэ. Тэдний зах зээлд эзлэх хувь, худалдан авах чадварыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хүний суурь эрх, эрх чөлөөг хангаж, тэднийг хүчирхэг хэрэглэгчид болгодог (НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага, 2024) хэмээжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай хэвлэл мэдээлэл дэх дүрслэл нь ихэвчлэн хэвшмэл байдаг бөгөөд энэ нь олон нийтийн үзэл бодолд сөргөөр нөлөөлж, ний-

гэмд оролцох, сурч боловсрох, ажиллах, хөгжих эрхээ эдлэх боломжийг нь хязгаарладаг байна. Хэвлэл мэдээллийн байгууллага үнэн зөв, шударга, хүртээмжтэй мэдээллээр дамжуулан гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалттай тэмцэж нийгмийн хандлагыг өөрчлөхөд тустай.

Хөгжлийн бэрхшээлийг хэрхэн мэдээлэх нь зүйтэй тухай өндөр хөгжилтэй орнуудын эрх зүйн болон бусад баримт бичигт тодорхой тусгасан байдаг байна. Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамгийн эхэнд анхаарах ёстой зүйл бол үг хэллэг, барих өнцөг, тэднийг дүрслэхдээ маш анхааралтай няхуур хандах ёстой. Аль болох бодит байдалд нийцсэн мэдээлийг төвийг сахисан байр сууриас, тэнцвэртэй мэдээлэхийг зорих нь чухал хэмээн зөвлөж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай мэдээлэхдээ дараах хэд хэдэн зарчмыг баримтлах нь зүйтэй гэжээ (<https://adata.org/factsheet/ADANN-writing>, 2013).

1. Тухайн хүн хөгжлийн бэрхшээлтэй гэдгээ онцлон илэрхийлэх хүсэлтэй байгаа эсэхийг тодруул. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрийг хөгжлийн бэрхшээлтэй гэдгээ олон нийтэд харуулах, тайлбарлах сонирхолтой байдаг гэж эндүүрч ойлгож болохгүй юм. Зарим хүн хөгжлийн бэрхшээлийнхээ талаар олон нийтэд мэдээлж өөрсдийнхөө бэрхшээл зовлонг ойлгуулан таниулахыг хүсдэг бол зарим нь хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдгээ олон нийтэд мэдүүлэхийг хүсдэггүй, мөн тухайн ярьж буй зүйлтэй шууд холбоогүй бол хөгжлийн бэрхшээлийн тухай холбон онцлох шаардлагагүй юм.

2. Бэрхшээл зовлонг биш амжилт бүтээлийг онцол. Тэдний хийж чадахгүй байгаа зүйлийн оронд юу хийж чадахыг, чаддагыг онцлон харуулах нь бусдад урам зориг өгдөг. Хүмүүс хийж чадахгүй зүйлийнхээ талаар бус хийж чадах зүйлийнхээ талаар ярихдаа илүү нээлттэй, итгэлтэй байдаг.

3. Эхлээд хүн гэдэг талаас нь харуулаад шаардлагатай бол хөгжлийн бэрхшээлийг хэлнэ. Нас, хүйс, нийгмийн байдал, өвчин эмгэг, гарал үүсэл шашин шүтлэг гээд хүнийг ямар нэгэн байдлаар дүрслэн үзүүлэх, ямар нэг зүйлтэй хамаатуулах нь дийлэнхдээ буруу хэвшмэл ойлголт руу хөтлөх хандлага төрүүлдэг. Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй ч тухайн хүний үзэл бодол, байр суурь, ажил мэргэжил бүхий л зүйлд нь дагалдах тэмдэг, нэр томъёо, шошго хаяг болно гэсэн үг биш юм Хөгжлийн бэрхшээл бол тэр хүний язгуур тодорхойлолт биш зүгээр л нөхцөл байдал төдий зүйл. Үүнийг “хүн төвт харилцаа” хэмээн нэрлэнэ.

4. Мэдээлэл өгөх гэж буй хүн өөрийгөө ямар байдлаар илэрхийлэхийг хүсэж буйг заавал сонс. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн тухай илэрхийлэх байр суурь нь харилцан адилгүй гэдгийн санаарай. Зарим нь хөгжлийн бэрхшээлээ өөрсдийнхөө салшгүй хэсэг гэж үздэг бөгөөд хамгийн түрүүнд өөрийгөө хөгжлийн бэрхшээлтэй гэдгээ таниулахыг хүсдэг.

5. Үг хэллэг зөв сонгох. Тухайн хүнийг сул дорой, чадавхигүй эсвэл ямар нэг зүйл дутагдаж, тусламж дэмжлэг хэрэгтэй байгааг илэрхийлсэн үг хэллэгийг ашиглахгүй байх.

6. Хөгжлийн бэрхшээлтэй гэхээсээ илүү хүртээмжтэй байх хэрэгцээг онцолсон хэллэгийг ашигла.

Хэрэглэж болох үгс	Хэрэглэж болохгүй үгс
Хүртээмжтэй зогсоол	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан зогсоол
Хүртээмжтэй ариун цэврийн өрөө	Хөгжлийн бэрхшээлтэй бие засах газар

7. Бусдыг гутаасан доромж үгийг бүү ашиглаарай. “Ялгаатай чадвартай”, “хөгжлийн бэрхшээлтэй”, “онцгой содон” зэрэг нэр томъёог ихэвчлэн гутаан доромжилсон гэж үздэг.

8. “Галзуу солиотой”, “хазгар доглон”, “тэнэг мангар”, “тахир дутуу”, “сэтгэцийн эмгэгтэй” зэрэг ялгаварлан гадуурхсан үг хэллэгийг бүү ашиглаарай.

9. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар мэдээлж, олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэхдээ хэвшмэл сөрөг ойлголтуудыг агуулсан үгсийг бүү ашигла.

10. Хөгжлийн бэрхшээл гэдэг нь өвчин биш буюу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өвчтөн биш гэдгийг санаарай. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үе мөчний үрэвсэл, чихрийн шижин зэрэг өвчтэй байж болох ч хөгжлийн бэрхшээл гэдэг нь өвчин биш гэдгийг ойлгох хэрэгтэй. Эрүүл мэнд болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой сэдвээр ярилцаж байх үедээ л өвчтөн гэх тодотголыг ашиглаж болно.

11. Сэтгэцийн эмгэгийн талаарх хэвшмэл сөрөг ойлголтыг даамжруулах үг хэллэгийг бүү ашиглаарай. Энэ төрлийн буруу ойлголт, гутаан доромжлолыг арилгахын тулд урт хугацаа, ихээхэн хүчин чармайлт

хэрэгтэй. Тиймдээ ч дэлхий даяар олон шинэ санаачилга хэрэгжиж буй бөгөөд жишээлбэл, Америкийн сэтгэцийн эмч нарын нийгэмлэг сэтгэцийн эрүүл мэндийн талаар зөв, бодитой мэдээлэх шинэ удирдамжтай болсон байна.

13. Өгүүлж буй агуулгад чухал биш л бол тухайн хүний хөгжлийн бэрхшээлийн талаар дурдах шаардлагагүй. Учир нь тухайн хүн хараагүй эсвэл тэргэнцэртэй байгаа нь таны нийтлэлд хамааралгүй байж болно. Тиймээс зайлшгүй шаардлагатай тохиолдолд л хөгжлийн бэрхшээлтэй гэж дурдаарай. Жишээлбэл, “ТУЗ-ийн ерөнхийлөгч, хараагүй Крис Жонс хурал зарласан” бус “ТУЗ-ийн ерөнхийлөгч Крис Жонс хурал зарласан” гэх нь зохимжтой.

14. Уянгалсан, өрөвдүүлсэн түүхээс илүүтэй бүх талыг харуулсан тэнцвэртэй агуулга бүтээгээрэй. Төрөлхийн согог, хүнд гэмтэл зэргийг гунигтай талаас нь харуулах нь энэ төрлийн хэвшмэл сөрөг ойлголтыг улам дэвэргэх болно хэмээн Америкийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах үндэсний сүлжээнээс гаргасан баримт бичигт өгүүлжээ. Энэхүү баримт бичиг нь ажил, сургууль, зам тээвэр, олон нийтийн газар зэрэг нийгмийн янз бүрийн салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахыг хориглодог бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд бусадтай адил тэгш эрх, боломжоор хангагдах нөхцлийг бүрдүүлэх зорилготой.

Монголын хэвлэл мэдээлэл хөгжлийн бэрхшээлийг хэрхэн мэдээлж буй судалгааг 2016 онд өдөр тутмын дөрвөн сонинд дээр хийж байсан билээ. Тэрхүү судалгаагаар уг сэд-

вийг маш бага анхаардаг, сэтгүүлчид болон нийгмийн ойлголт сул, үг хэллэг, хандлагаар ялгаварлан гадуурхсан өнгө аяс их, зөвхөн ХБИ эрхийн өдөрт зориулсан тусгай өдрөөр голдуу дуу хоолойг нь сонсдог дүр зураг гарсан юм.

Найман жилийн дараа хийж буй энэ удаагийн судалгаагаар тэргүүлэгч мэдээллийн сайтуудын мэдээлэлд дүн шинжилгээ хийлээ. Судалгааны хамрах хүрээгээ 2020 оноос хойших мэдээллийг сонгон авсан бөгөөд дөрвөн жилийн хугацаанд 35-48 орчим мэдээлэл нийтэлжээ. Өмнөх судалгаагаар жилд 10 орчим мэдээлэл гаргадаг хэмжээтэй адил байгаа юм. Өөрөөр хэлбэл бусад сэдэвтэй харьцуулахад бага нийтэлж байна гэсэн дүгнэлт өгөхөөр байна. Гэхдээ сайтуудад зөвхөн “хөгжлийн бэрхшээл” гэсэн түлхүүр үгээр хайлт хийж гарч ирсэн мэдээлэлд анализ хийсэн гэдгээ дурдах нь зүйтэй байх.




График №1. 2020-2024 онд ХБИ-ийн асуудлаар сайтуудад мэдээлсэн байдал.

Хөгжлийн бэрхшээлийг мэдээлэхдээ ямар агуулга, байр сууринаас мэдээлж байгааг авч үзвэл өмнөх

судалгаанаас их өөр өнгө аястай байсныг онцолмоор байна. Өмнө нь өрөвдүүдсэн, ялгаварласан, бусдаас өөр гэж харуулсан байдлаар их бичиж байсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн бол бусдаас өөр, тэдэнд нийгмийн халамж тусламж хэрэгтэй, өрөвдмөөр хүмүүс гэсэн ойлголт өгөхөөр мэдээ мэдээлэл түлхүү байсан ба зөвөөр ойлгуулах өнцгөөс бичсэн мэдээлэл нь голдуу ХБИ-ийн өөрсдийн зохион байгуулсан үйл

ажиллагаа, өөрсдийгөө ойлгуулах гэж оролдсон хандлага байгаа нь илэрч байсан юм. Энэ удаагийн мэдээллийн сайтуудад хийсэн судалгаагаар нийгэмд зөвөөр ойлгуулах, бусадтай адилхан хүн гэдэг талаас нь үзүүлэх, тулгамдсан асуудал, нийгмийн халамжийн талаар хөндөхдөө илүү системтэй бодлого, хөтөлбөрийн түвшинд авч үзэж байгаа нь ажиглагдлаа.




График №2. ХБИ-ийн асуудлаар тусгаж буй өнцөг, сэдвүүд.

Тулгамдсан асуудлыг тусгасан мэдээлэлд ямар агуулгууд байгааг ажиглавал,

- Паралимпын тамирчдад тусгай хэрэгцээт тоног төхөөрөмж бүхий спортын ордон үгүй
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах хүмүүсийн хандлага өөрчлөгдсөн ч төр засгийн хандлага өөрчлөгдөхгүй байна
- Эдгээр хүмүүсийн эрх ашгийг хамгаалах, нийгэмд бидэнтэй адилхан оролцох ёстой гэдгийг ойлгуулж, хандлагыг нь өөрчлөх контентууд хийж байна

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, нийгмийн амьдралд саадгүй оролцох, бие даан амьдрах боломжийг бүрдүүлэх тулгуур зүйл нь нийтийн зам талбай, барилга байгууламж, нийтийн тээврийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх явдал юм

Нийгмийн халамж эрх зүйн орчинг сайжруулж буй тухай- Энэ ангилалын мэдээ, нийтлэлүүдэд гарч буй санааг тоймолбол,

- Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах нийслэлийн салбар

зөвлөл өнөөдөр ээлжит хурлаа хийлээ.

- Засгийн газрын өнөөдрийн хуралдаанаар нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг сард 188 мянган төгрөгөөр, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч байгаа иргэнд олгох асаргааны тэтгэмжийг сард 123100, бусад асаргааны тэтгэмжийг сард 84500 төгрөг болгон шинэчлэн тогтоолоо
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэж баталсан тухай Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын сайд А.Ариунзаяа мэдээллээ
- Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа /2024.05.28/ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт өргөн мэдүүлжээ.

Суралцах орчин- Энэ ангилалын мэдээ, нийтлэлүүдэд гарч буй санааг тоймолбол,

- Япон Улсын засгийн газрын 2 тэрбум 379 иений буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэгч байгууллага болох ЖАЙКА-гаар дамжуулан нийслэлийн дөрвөн дүүрэгт дөрвөн сургуулийн барилга, өргөтгөлийг 2017-2021 оны хооронд барьсан. Үүний нэг нь Чингэлтэй дүүргийн 7-р хорооны 149-р сургууль аж.
- Манай улсын боловсролын холбогдох хууль тогтоомжид ялгаатай

хэрэгцээтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд ялгаварлан гадуурхалгүй тэгш хамран сургах талаар тусгаж өгсөн байдаг.

- Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй өрөө, танхимтай Үндэсний номын сангийн шинэ байр үүдээ нээлээ

Хөдөлмөр эрхлэлт- Энэ ангилалын мэдээ, нийтлэлүүдэд гарч буй үзэл санааг тоймолбол,

- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж буй сайн жишээ” цуврал нийтлэлүүд ikon.mn дээр гарч байсан
- Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газраас ХБИ ийг төрийн албанд ажиллаж боломж бүрдүүлэхээр ТАЗ-тэй хамтран ажиллаж байгаа аж
- Монгол Улс дахь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх /DPUB2/ төсөл”-ийн хүрээнд бэлтгэгдсэн ААН-үүдэд нөлөөлөх нөлөөллийн багийн гишүүн Х.Батчимэг, Х.Мөнхтуул нар Нагоя хотод суусан сургалтаас мэдсэн сурснаа албан байгууллагуудад танилцуулах, хөгжлийн бэрхшээлийн талаар олон нийтийн дунд тогтсон зөрүүтэй ойлголтыг залруулах зорилгоор энэхүү сургалтыг зохион байгуулсан юм.

Эерэг дүр – Энэ маш үр нөлөөтэй байж болох, сонирхолтой уншууртай ярилцлага, сурвалжилгыг gogo.mn, ikon.mn, news.mn аль аль сайтууд тусгасан байсан тун сайшаалтай. Энэ ангилалын мэдээ, нийтлэлүүдэд гарч буй үзэл санааг тоймолбол,

- News агентлаг залууст зориулсан “Шинэ нэр” булангийнхаа ээлжит

зочноор сонсголгүй иргэдийн тэргүүн Мисс бүсгүйг онцолж байна

- “Эерэг дүр” кино уран бүтээлч залуу
- Паралимпийн алтан медалт
- Жирийн хөдөлмөрч залуутай хийсэн ярилцлага гэх мэт материалууд байлаа

Зөв ойлголт өгөх - Хөгжлийн бэрхшээлтэй амьдарч байгаа хүмүүсийн зүрх сэтгэлд ямархан бодол хүсэл байдгийг анхаарч сонсож, илүү олон хүнд түгээх нь чухал гэсэн үзэл санааг тусгасан нийтлэлүүд. Энэ ангилалын мэдээ, нийтлэлүүдэд гарч буй үзэл санааг тоймолбол,

- Хүмүүсээс алсрах тусам нийгмийн харилцаанд орохыг хүсдэг юм билээ. Гэрээс гаръя гэвч орноосоо ч бууж чадахгүй хүн хаа хүрэх вэ? Тиймээс надад тусалж чадах хүмүүсийг хайсаар “Түгээмэл хөгжлийн төв” ТББ-тай цахимаар холбогдсон. Танайх ямар үйл ажиллагаа явуулдаг вэ, надад ямар боломжууд байгаа вэ гэдгийг

лавласаар “Бие даан амьдрах хөтөлбөр” богино хугацааны сургалтад хамрагдсан

- “Бид Чадна” байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэдээллээр хангах, ажлын байртай болоход нь туслах, тэдэнд хандах нийгмийн, тэр дундаа залуусын хандлагыг өөрчлөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.
- Хотын соёлыг түгээх “Соёлын довтолгоо” булангийнхаа энэ удаагийн дугаараар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг хөндөж байна. Их хотын соёлч иргэд бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцахдаа заавал мэдэж байх ёстой хэд хэдэн зүйлийг сануулъя.
- Олон нийтийн хандлага, ялгаварлан гадуурхалт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрийгөө тусгаарлах, цоожтой хаалганы цаана нуух хамгийн том шалтгаануудын нэг болж байгаа нь харамсалтай.

Өмнө хийсэн судалгааны агуулгатай харьцуулан авч үзвэл:

2013-2016 он	2020-2024
ХБИ-д орчин байхгүй, тэдэнд тусламж хэрэгтэй	Тулгамдсан асуудал. ХБИ-д орчин байхгүй, тэдэнд тусламж хэрэгтэй /шийдвэрлэж буй жишээ/
ХБИ-г төр анхааралдаа авах хэрэгтэй байна	Нийгмийн халамж эрх зүйн орчинг сайжруулж буй тухай
ХБИ-д туслаж байна, ХБИ-дэд зориулсан үйлчилгээ бий болсон тухай	ХБИ-д туслаж байна, ХБИ-дэд зориулсан үйлчилгээ бий болсон тухай
	Суралцах орчин
ХБИ-ийн хөдөлмөр ажил эрхлэлтийн тухай, тэднийг нийгэмд зөвөөр таниулах өнгө аястай	ХБИ-ийн хөдөлмөр ажил эрхлэлтийн тухай
ХБИ-ийн тоо өссөөр байна	
	Эерэг дүр
	Зөвөөр ойлгуулах

Найман жилийн өмнө мэдээлж байсан байдалтай харьцуулахад мэдэгдэхүйц дэвшил гарсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тулгамдсан асуудлыг тоочиж, тусламж, дэмжлэг хэрэгтэй байна гэхээсээ илүү хэрхэн шийдвэрлэж байгааг тусгаж, нийгэмд амжилттай ажил хөдөлмөр эрхлэж буй иргэдийн үзэл бодол, амьдралын хэмнэлийг харуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж буй байгууллага болон тэр иргэний байгууллагадаа оруулж буй хувь нэмэр, авьяас чадварыг тодотгон, нийгэмд байдаг хэвшмэл ойлголт, сөрөг хандлагыг шүүмжилж бичсэн нийтлэл цөөнгүй байгаа нь буруу

ойлголт, ялгаварлан гадуурхалтыг зогсоох ач холбогдолтой юм.

Бичлэгийн төрөл зүйлийн хувьд нийт дүнгээрээ сурвалжилга түлхүү байгаа нь мөн өмнөх судалгаанаас ялгаатай үзүүлэлт гарч байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай асуудлыг үйл явдын мэдээгээр голдуу тусгаж байсан нь үр нөлөө багатай бөгөөд нийгмийн хэвшмэл буруу ойлголт, хандлагыг төлөвшүүлэхэд тэдний өөрсийн байр суурь үзэл хандлага бүхий ярилцлага, ойлголт мэдлэг өгөх танин мэдэхүйн мэдлэг мэдээлэл ихтэй сурвалжилга нийтлэл нь өндөр үр нөлөөтэй билээ.




График №3. ХБИ-ийн асуудлаарх сэтгүүл зүйн бичвэрүүдийн зүйлүүд.

Жишээ болгож хэд хэдэн сурвалжилгаас эш авбал: Gogo.mn сайтад гарсан “Би эвдэрхий хүн биш” сурвалжилгад “Тэр нэгдүгээр курсийн оюутан. Цахим үйлчилгээний ажилтны ангид суралцдаг. н.Пүрэвжаргал ютүбер болохыг хүсдэг. Тэгээд хөгжлийн бэрхшээл бол өвчин биш. Энэ бол ичих ч зүйл биш гэдгийг олон нийтэд ойлгуулахын тулд найзуудтайгаа хөгжилдөж байгаагаа, сурч, ажил хийж, зүгээр л

амьдарч байгаагаа харуулсан бичлэгүүд нийтэлнэ. Бас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуус, хүмүүст битгий бууж өгөөрэй, битгий шантраарай. Чи эвдэрхий биш, чи бусдаас арчаагүй биш. Чи зүгээр л содон бүтээл гэж хэлэхийг хүсдэг гэв.” News.mn сайтад “Аутизм бол бэрхшээл биш” сурвалжилгад “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд боловсролын хүртээмжийг тэгш

болгож, нийгмийн шударга ёсыг тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чанартай боловсрол олгох замаар халамж хүртэгчдийн тоог бууруулж, татвар төлөгчдийн тоог нэмэгдүүлэх өөрсдийн санал, бодлогын шийдлийг энэхүү видеоогоор санал болгож байна. Gogo.mn сайтад “Нэг хүн хөгжлийн бэрхшээлтэй болоход дагаад зургаан хүнд хөгжлийн бэрхшээл тулгардаг” гарчигт сурвалжилгад “Мөн надтай ижил бэрхшээлтэй хүмүүс тулгамдсан асуудлаа хэрхэн даван туулсан туршлагаа нэгэндээ хуваалцдаг. Бие дааж гэрээс гарахын тулд орон сууцаа өөрчилсөн. Нэг давхарт, ямар ч босгогүй, илүү том байртай болсон. Байр томруулах шалтгаан нь хөгжлийн хөдөлгөөний бэрхшээлийн тохируулгатай ор, хэрэглүүрүүд бүгд энгийн тавилга хэрэгслээс том байдаг. Гараа өргөөд хаал-

гаа онгойлгож чадахгүй болохоор хаалганыхаа цоожийг хүртэл сольсон. Ухаалаг цоож суулгаж утас-тайгаа холбосноор зайнаас хаалгаа онгойлгодог болсон” за мөн Ikon.mn сайтын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж буй сайн жишээ” цуврал сурвалжилгууд агуулга, хандлага, ур чадварын хувьд маш сайн байлаа.

Өмнөх судалгааны гол дүгнэлт болох үг хэллэгээр ялгаварласан байдал буюу хөгжлийн бэрхшээлээр нь онцолсон гарчиг их байгааг дурдаж байсан. Энэ удаагийн судалгааг энэ түлхүүр үгээр сайтуудаас хайсан ба, мөн угаас энэ ойлголыг энэ үг өгүүлбэргүйгээр илэрхийлэх боломж хязгаарлагдмал байдагтай холбоотой юу нийт нийтлэл материалын 70 орчим хувь нь “хөгжлийн бэрхшээл” гэдэг үгийг оруулсан гарчигтай байна.




График №4. ХБИ-ийн асуудлаарх бичвэрүүдийн гарчиг дахь үг хэллэг.




График №5. ХБИ-ийн асуудлаарх бичвэрүүдийн гарчиг дахь үг хэллэг.

Хөгжлийн бэрхшээл гэдэг үгээр тодорхойлж онцлохоос зайлсхийх нь ялгаварлан гадуурхалт, хэвшмэл буруу ойлголтоос зайлхийж, эерэг зөв ойлголт өгөх сайн үр нөлөөтэй билээ.

- М.Салтанат: Бусадтай мөр зэрэгцэн ажилдаа явах тэр мэдрэмж хамгийн сайхан /ikon.mn/
- Охинтойгоо энгийн сургуульд сурахад маш хүнд байсан /news.mn/
- "Иргэдийн хандлага өөрчлөгдсөн ч төрийнх өөрчлөгдсөнгүй" /news.mn/
- Нийгэмдээ "гологдсон" хүүхдүүд /news.mn/
- Бидэнд халамж биш хүртээмж дутагдаж байна /gogo.mn/
- Хувь тавилангийн эзэн /gogo.mn/ зэрэг сайн гарчигт, сайн мэдээ, сурвалжлагууд байсныг дурдах хэрэгтэй юм.

Хамгийн сүүлийн үеийн тоо баримтаар Монгол Улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 115115 хүн бүртгэлтэй байгаагаас 8208 буюу 7-8 хувь нь албан ёсоор хөдөлмөр эрхэлдэг. 9588 хүн хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 4621 нь гэрийн ажилдаа туслах зэргээр хөдөлмөрлөж гэртээ байдаг гэж 2020 оны ХБИ-ийн ахуй амьдралын судалгаанд дурджээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг хүчин чармайлт, хийж хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн үр дүн гарч байгаа нь бидний хийсэн энэхүү судалгаагаар харагдаж байна гэж үзлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалд өртөхөөс хамгаалах, хориглох, нийгмийн харилцаанд бусдын

адил тэгш эрхтэйгээр оролцох боломжийг бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг өөрчлөх, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулах зэрэг чиглэлээр ажиллах нь зөвхөн төр засаг, Хөгжлийн бэрхшээлийн иргэд, тэдний эрх ашгийг хамгаалдаг байгууллагуудын үйл ажиллагаа биш хэвлэл мэдээллийнхэн бидний ч бас үүрэг билээ. “Хүний Эрхийн хандлагаар хөгжлийн бэрхшээл гэдэг нь хүний ялгаатай байдлын нэг хэлбэр бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь сул дорой, эсвэл хэн нэгний буруутай үйлдлийн золиос биш” гэдгийг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч конвенцийг баталж хууль гаргасан. Тиймээс хүний эрхэд суурилсан сэтгүүл зүйг хөгжүүлэхэд нэг том сэдэв, салбар нь хөгжлийн бэрхшээлийг зөв ойлгож мэдээлэх байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог хэрэгцээг бодолцохгүйгээр хийсэн аливаа зүйл хожим нь маш их эдийн засгийн хохиртойг онцолсон байдаг. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон талт байдлыг тусгаж, нийгэмд зөв ойлголцол эерэг хандлагыг түгээснээрээ уншигч, сонсогч, үзэгчийнхээ итгэлийг олж, хэрэглэгчдээ татах илүү олон хэрэглэгчтэй болох эерэг үр нөлөө ирдэг хэмээн судлаачид тэмдэглэж байна. Тэгэхээр зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалж буй нэг талт харилцаа биш хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрийн хэрэглэгчийг татах, тэдний итгэл үнэмшлийг олж авах харилцан ашигтай хоёр талт харилцаа гэдгийг ойлгож ухамсарлах нь чухал байна.

Энэ удаагийн судалгааны үр дүнг харахад тоо хэмжээний хувьд бага хэвээр байгаа боловч чанар агуулгын хувьд дэвшил гарсан, олон улсад зөвлөж байгаа сэдэв, агуулгаар тусгаж нийгэм зөв ойлголт өгөх, буруу хэвшмэл ойлголтыг засахад үр нөлөө үзүүлэхээр бичиж тусгажээ. Энэ бүхэн нь төр засгаас энэ талаар авч хэрэгжүүлж буй томоохон бодлого үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон эрх ашгийг хамгаалдаг байгууллагуудын хамтран хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн шууд үр дүн гэж дүгнэж байна. Тэр тусмаа Японы Жайка олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн үр нөлөө их байгаа нь харагдаж байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. People First Language and More, Disability is Natural (link is external) Guidelines: How to Write and Report About People with Disabilities, and “Your Words, Our Image(link is external)” (poster), Research & Training Center on Independent Living, University of Kansas, 8th Edition, 2013.
2. Mental Health Terminology: Words Matter and “Associated Press Style Book on Mental Illness,(link is external)” American Psychiatric Association, 2013.
3. “Disability,” Fact Sheets, World Health Organization (WHO), updated 7 March 2023. <https://www.who.int/news-room/fact-sheets/detail/disability-and-health>
4. “Women and Girls with Disabilities,” UN-Women, last modified 2023. <https://www.unwomen.org/en/what-we-do/women-and-girls-with-disabilities>
5. “UNESCO Launches Updated Handbook on Media Reporting for Promoting Disability Equality in China,” News, UNESCO, published December 2021. <https://www.unesco.org/en/articles/unesco-launches-updated-handbook-media-reporting-promoting-disability-equality-china>
6. UNESCO Хэвлэл мэдээллийн хэрэглээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэгш байдлыг хангах гарын авлага., УБ. 2024
7. mlsp.gov.mn- Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам
8. gadpwd.gov.mn-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
9. www.jica.go.jp/Resource/project/mongolian/mongolia/030/index.html
10. legalinfo.mn/mn/detail/11711- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай хууль
11. news.mn
12. gogo.mn
13. ikon.mn

Summary

The appropriate way to report on disability issues is clearly outlined in the legal frameworks and other official documents of developed countries. Journalists and media outlets must give particular attention to their choice of language, framing of the issue, and portrayal of individuals with developmental challenges. It is advised to report news as closely as possible to reality, from a neutral stance, with a balanced perspective.

In comparison to how these issues were reported eight years ago, considerable progress has been observed. Rather than merely listing the problems faced by people with developmental challenges and focusing on their need for assistance, modern reporting highlights how such challenges are being addressed. The media now increasingly emphasizes the perspectives, lifestyles, and

contributions of individuals with developmental challenges who are successfully engaged in work and social activities. This shift includes recognizing the talent and skills that individuals with developmental challenges bring to their organizations. Furthermore, several articles critically examine and challenge

the stereotypical perceptions and negative attitudes towards people with developmental challenges in society, which is essential in reducing misconceptions and combating discrimination.

Keywords: disability, coverage, news websites, topics, understanding disability.